

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-28

1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийг сонсох 5-17

2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох 17-28

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 49 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнхбат, С.Цэнгүүн, Ж.Чинбүрэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болох Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийг сонсох асуудлыг нэгдүгээр асуудал болгон хэлэлцэх горимын санал гаргав.

Ж.Золжаргал: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 1

Бүгд: 8

87.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэхээр тогтов.

Нэг.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Долгорсүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны дарга У.Ганчимэг, мөн газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны ахлах хянан шалгагч Б.Цолмонтуяа, хянан шалгагч Б.Номинчулуун, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтсийн мэргэжилтэн Д.Эрдэнэхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ байлцав.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар, Л.Соронзонболд, Ч.Ундрэм, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ж.Галбадрах, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулууны мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, мөн яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Бат-Өлзий, мөн газрын Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч Ч.Болор-Эрдэнэ, Цахим засаглалын хэлтсийн Салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч Г.Энхтулга, Дэмжих систем хариуцсан шинжээч Б.Отгонбаяр, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, И-Монгол академийн захирал Б.Мягмарнаран, Үндэсний дата төвийн захирал М.Баттулга, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирал С.Жавхлан, Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга Д.Батбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх М.Тулгат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ байлцав.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, мөн Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Бат-Өлзий, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх М.Тулгат, Төрийн цахим

үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Одын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 27 минут үргэлжилж, 13 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 76.9 хувийн ирцтэйгээр 16 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис” танхим
14 цаг 49 минут.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Ирц 53.8 хувь байна. Чинбаатарын Анар гишүүн ирсэн байна. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн байна. Жанчивын Галбадрах гишүүн ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал байгаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн ирсэн байна. Чинбатын Ундром гишүүн байгаа.

Та бүхэндээ идэвхтэй оролцож байгаад баярлалаа. Хэлэлцэх асуудлын хувьд 2 асуудал байгаа.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох.

Хоёрдугаарт нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийг сонсох гээд ийм 2 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Соронзонболд гишүүн дараалалыг нь өөрчилье гэсэн санал тавьсан байгаа тээ? Тийм, та саналаа хэлэх үү Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Яах вэ, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх сонсголоо эхлээд хийвэл бас их сайн байна л гэж миний санал байгаад байгаа юм. Бас нэг ажлын хэсгийн хурал давхцаж байна.

Ж.Золжаргал: Чинбатын Номин гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн нар хуралдаа ирсэн байна. Баярлалаа.

Соронзонболд гишүүний гаргасан саналын дагуу Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийг сонсохыг нэгдүгээрт болгоё, болгохыг дэмжье гэсэн томъёогоор санал хураая.

Санал хураалт дэмжигдлээ. 87.5 хувиар.

Тэгэхээр хэлэлцэх асуудал нэг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Санхүүгийн зохицуулах хороо мэдээлэл өгнө.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрдлийг танилцуулъя.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Хүдэрчулуун. Хүдэрчулуун дарга 4 номер, Хяналт шалгалт зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Долгорсүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Мөнх-Оргил? Мөнх-Оргил дарга ирээгүй. Байна уу? 3 нь Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ганчимэг, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны ахлах хянан шалгагч Цолмонтуяа, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны хянан шалгагч Номинчулуун, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтсийн мэргэжилтэн Эрдэнэхүү, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтсийн мэргэжилтэн Дэлгэрмаа. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Виртуал хөрөнгийн талаар Байнгын хороон дээр бас урьд нь энэ салбарын хүмүүс Виртуал хөрөнгийн биржүүдийн холбооныхон энэ тэр мэдээлэл өгсөн. Түүний дагуу Санхүүгийн зохицуулах хороо болоод Сангийн яам руу бид нар албан бичгээр хандаж Монгол Улсад бүртгэлгүй виртуал хөрөнгийн биржийн үйл ажиллагааг хэрхэн зохицуулах вэ гэх мэт асуудлаар бас урьд нь ярьсан зүйл байгаа.

Тэгэхээр энэ болоод бусад асуудлын талаар юуны өмнө Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Хүдэрчулуун танилцуулга хийнэ үү.

4 Номерын микрофон.

Н.Хүдэрчулуун: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Санхүүгийн зохицуулах хорооноос энэ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар танилцуулгыг танилцуулъя.

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэгч байгууллага болох ФАТФ-аас 2018 оны 10 дугаар сар, 2019 оны 6 дугаар сард энэ техникийн зөвлөмж 15 буюу шинэ технологи гэдэг энэ зөвлөмжид нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.

Өөрөөр хэлбэл, виртуал хөрөнгөтэй холбоотой энэ шинэ зохицуулалтыг энэ зөвлөмж 15-д хэрхэн тусгах талаарх энэ зөвлөмжүүдийг дэлхийн улс орнуудад хүргүүлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, нэгдүгээрт энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэлжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, эсвэл тухайн улс орон бүрэн хориглох, мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, бууруулах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага, мөн хяналт шалгалтыг тогтмол эрсдэлд суурилсан аргачлалаар хэрэгжүүлэх, тухайн улсад үүсгэн байгуулагдсан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэж, зохицуулах төрийн захиргааны байгууллагыг томилох, мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагуудыг биелүүлэхийг үүрэг болгох, биелэлтэд нь хяналт тавих, 6 дугаарт нь зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэгчдэд шийтгэлийн

арга хэмжээг хууль, эрх зүйн хүрээнд мөрдүүлэх гэсэн ийм үндсэн ийм зөвлөмжийг улс орнуудад хүргэгдсэн байдаг.

Эдгээр зөвлөмжийг бүх улсуудад яаралтай горимоор шийд гэдэг ийм зөвлөмжийг ФАТФ-аас өгсөн. Монгол Улс энэ Виртуал хөрөнгийн үйлчилгээний тухай хууль гарахаас өмнө нөхцөл байдал ямар байсан бэ гэдэг талаар товч timeline-ыг танилцуулъя.

Анх 2017 оны 10 дугаар сард trade.mn гэдэг платформ дээр гаднын койн токenuудыг арилждаг ийм арилжааны платформыг нэвтрүүлээд Монгол Улсад анх энэ виртуал хөрөнгөтэй холбоотой харилцаа үүссэн гэж ингэж үздэг. Ингээд 2020 оны 12 дугаар сард гэхэд banks.mn гэдэг 2 дахь бирж, Ардкойн гэдэг анхны койн Монгол Улсад үүссэн.

Тухайн үед ямар нэгэн хууль, эрх зүйн зохицуулалт огт байгаагүй учраас ФАТФ-ын энэ өгч байгаа зөвлөмжид тусгагдсан нэг агуулга бол тухайн улс орны зохицуулагч байгууллагууд албан энэ талаарх ойлголт мэдээллийг аж ахуй, иргэдэд сурталчлан таниул гэдэг эрсдэлийн талаарх ийм үүрэг бас хүлээдэг. Энэ агуулгаараа Санхүүгийн зохицуулах хорооноос энэ 20 оноос, 21 оны 12 сая буюу Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдах хүртэл хугацаанд энэ виртуал хөрөнгө гэдэг бол албан ёсны төлбөр тооцооны хэрэгсэл огт биш. Төрийн байгууллагын ямар нэгэн зохицуулалтгүй явж байгаа салбар, мөн та мөнгө угаах, терроризмыг санхүүжилттэй тэмцэх энэ эрсдэлд өртөх өндөр магадлалтай шүү.

Дээрээс нь үнэ ханшийн хэлбэлзэл маш өндөр байдаг учраас иргэд энэ ханшийн хэлбэлзлээс болж маш их хэмжээний алдагдал хүлээх боломжтой гэсэн ийм агуулга бүхий нийт 40 гаруй удаагийн анхааруулах сэрэмжлэгүүдийг төрийн болон дангаараа болон төрийн бусад байгууллагад холбогдох байгууллагатай хамтран мэдээллийг өгч ажилласан байдаг.

2021 оны 12 дугаар сард энэ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдах хүртэл хугацаанд нийт Монгол Улсад 66 койн, 24 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч үйл ажиллагаа явуулж байсан ийм дүр зурагтай байсан.

Ингээд ФАТФ-аас тавьж байгаа үндсэн техникийн шаардлагуудыг хангах, мөн олон улсын нийтлэг сайн жишгүүдийг тусгаад Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг өргөн баригдсан байдаг. Энэ хууль маань 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар батлагдаж төрийн мэдээллийн эмхэтгэлийн 2022 оны 2 сарын 14-ний өдөр өдрийн дугаар 06-д хэвлэгдсэн бөгөөд энэ 2 сарын 24-нөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Энэ хуультай мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдсанаар дараах нэр бүхий 13 хууль тогтоомжид бас нэмэлт, өөрчлөлт орсон ийм зохицуулалт болсон.

Тухайн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн гол зорилго бол виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, холбогдох эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байсан. Хамрах хүрээний хувьд Монгол Улсад бүртгэлтэй компани, Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улс руу энэ

хуульд заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг хамаарч байсан. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний харилцагчийн хооронд хийгдсэн гэрээ хэлцлээс үүсэх маргаантай холбогдсон харилцааг энэ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулиар зохицуулахгүй гэдэг ийм зохицуулалтыг тодорхой тусгаж өгсөн байгаа юм.

Виртуал хөрөнгийн аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт биш үнэт цаасны дижитал хэлбэр, эсвэл Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсвэл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэний дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгө гэж энэ хуулиар анх Монгол Улсад энэ виртуал хөрөнгө гэдэг нэр томъёог хуульчилж өгсөн байгаа.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээнд юу багтах вэ гэдгийг энэ хуулийн 6.1-д бас тодорхой зааж өгсөн. Хувь хүн, хуулийн этгээд гэрээ, хэлцэлд оролцогчийн нэрийн өмнөөс тэдгээрийн захиалгаар, эсвэл тэдгээрт зориулан үзүүлэх виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарах дараах үйл ажиллагаа хамаарна гэсэн ийм 5 төрлийн үйл ажиллагааг зааж өгсөн.

Энэ нь бол виртуал хөрөнгийг арилжих, хадгалах, удирдах, шилжүүлэх, олон нийтэд санал болгох үйл ажиллагаатай холбоотой ийм 5 төрлийн үйл ажиллагааг виртуал хөрөнгийн үйл ажиллагаа гэж үзнэ. Энэ 5 төрлийн үйл ажиллагааг эрхэлж байвал виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч гэж үзнэ гэсэн ийм агуулгаар энэ хуульд тусгагдсан.

Хуультай холбоотой онцлох бас зохицуулалтаас дурдъя. Энд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлдээ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжихгүйгээр нийтэд санал болгох, худалдахыг шууд хориглосон. Өөрөөр хэлбэл, өмнө нь, урьд өмнө нь жишгээр гарч байсан Ай Си Өү гаргах Ай Ди Өү гаргах гэдэг юм уу энэ тухайн виртуал хөрөнгө гаргагч нь өөр дээрээ олон нийтээс хөрөнгө татдаг энэ үйл ажиллагааг энэ хуулиар шууд хориглосон.

Өөрөөр хэлбэл, зөвхөн Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулж энэ койн токеныг гаргаж болно гэдэг энэ зохицуулалтыг орж ирсэн.

Дараагийн нэг онцлох зохицуулалт бол энэ зар сурталчилгааны тухай тодорхой зааж өгсөн. Нийтэд санал болгож байгаа, болгох, худалдах виртуал хөрөнгийн талаарх танилцуулга, мэдээлэл дутуу, худлаа төөрөгдүүлсэн мэдээллийг тусгаж нийтэд танилцуулах, эсвэл хязгаарлалт тогтоосон виртуал хөрөнгийг сурталчлах, мөн виртуал хөрөнгийг эзэмших, арилжаанд оролцсоноор олох ашиг өгөөжийн талаар таамаглал дэвшүүлэлт, амлалт өгөхийг хориглосон. Мөн виртуал хөрөнгийг үнэт цаас, компанийн хувьцаа болон бусад санхүүгийн хэрэгсэл үйлчилгээтэй адилтган сурталчлахыг энэ хуулиар хориглосон байгаа.

Нэг бас онцлох зохицуулалт нь бол энэ дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах, арилжааг урвуулан ашиглах тохиолдолд гэмт хэрэгт тооцох энэ зохицуулалт энэ хууль дээр орж өгсөн. Өөрөөр хэлбэл, market manipulation хийсэн тохиолдолд цагдаа болон тагнуулын байгууллагын харьяан дор энэ хэрэг шалгагдах, гэмт хэргийн ийм зүйлчлэлээр хатуу ийм заалт тусгагдсан байгаа.

Бас нэг онцлог заалт бол энэ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэснийг тухайн виртуал хөрөнгөд өгч байгаа баталгаа гэж огт үзэхгүй бөгөөд виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнд үүсэж байгаа хохирлыг төр хариуцахгүй гэдэг ийм бас зохицуулалтыг энэ хуульд тусгаж өгсөн байдаг.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль 2022 оны 2 сарын 24-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ үеэс энэ хуульд нэг онцлог зохицуулалт нь шилжилтийн үеийн зохицуулалтыг тодорхойлж өгсөн байж байгаа.

Өөрөөр хэлбэл, шилжилтийн үеийн 4 сарын хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд дараах нэр бүхий 8 журмыг 4 сарын хугацаанд багтааж захиргааны хэм хэмжээний актад нийцүүлж энэ журмуудыг батламжлах, улмаар энэ үйл ажиллагаа дууссаны дараа 3 сарын хугацаанд урьд өмнө үйл ажиллагаа явуулж байсан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг хууль, дүрэм, журмын шаардлагад нийцсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх эсэх дүгнэлтийг гаргана гэсэн ийм онцлог зохицуулалт тусгагдсан.

Энэ хүрээндээ Санхүүгийн зохицуулах хороо хуульд заагдсан энэ хугацаанд энэ 8 журмыг захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлж, албан ёсоор хуулийн хэрэгжилтийг хангуулж ажилласан болно.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдахаас өмнө нийт 24 виртуал хөрөнгийн үйл ажиллагаа үйл ажиллагаа явуулдаг ийм эксченжүүд байсан. Нийт хороонд 15 хүсэлт тухайн үед ирсэн. Хороод холбогдох хууль тогтоомж болон журмын шаардлагуудыг хангахгүй байгаа 3 биржид татгалзсан, хорооноос бүртгэхгүй гэдэг ийм татгалзсан шийдвэр гарсан байдаг. Хууль, дүрэм, журмын шаардлага хангаж байгаа нийт 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэж авсан.

Энэ нийт өмнө үйл ажиллагаа явуулж байсан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид бол энэ 9 сарын 27-ны өдрийн дотор хороонд ямар нэгэн байдлаар хүсэлтээ гаргах ийм үүргийг хүлээсэн. Хороо хуульд заасан хугацааны хүрээнд нийт 10 биржийн үйл ажиллагааг зөвшөөрсөн.

2023 оны 1 сарын 13-нд бас цоо шинээр урьд өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаа 2 бирж бас хүсэлтээ хороонд хүргүүлсэн. Хуулийн тодорхой шаардлагуудыг хангасан учраас хороо энийг бүртгэж авсан. Нийт ингээд хороонд өнөөдрийн байдлаар бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйл ажиллагаа эрхлэгч үйл ажиллагаа явуулж байна.

Мөн хуульд энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг хороо бүртгэж, шаардлагуудыг тавьж, тухайн шаардлагыг хангасан хуулийн этгээдийг бүртгэнэ гэсэн ийм зохицуулалт байж байгаа.

Өнөөдрийн байдлаар хороонд 6 аудитын компани энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх этгээдээр бүртгэгдсэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Ж.Золжаргал: 4 номерын микрофон нэмээд нээгээд өгөөрэй.

Н.Хүдэрчулуун: Виртуал хөрөнгийн салбарын бас нэг онцлох ажил бол энэ Монгол Улсын үндэсний эрсдэлийн үнэлгээг анх энэ 2022 онд хийж гүйцэтгэсэн байж байгаа. Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хамтарсан тушаалаар нийт эрх бүхий төрийн 10 байгууллагын 27 гишүүнээс бүрдсэн энэ эрсдэлийн үнэлгээ хийж, энэ эрсдэлийн үнэлгээ дээр суурилсан виртуал хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг хэрхэн бууруулах, зөв тогтолцоог бүрдүүлэх ийм чухал ач холбогдолтой ажил болсон. Монгол Улсад анх удаа энэ виртуал хөрөнгийн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн ийм чухал ажил болсонб

Эрсдэлийн үнэлгээнээс товч танилцуулъя. Нийт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн түвшин нийт эрсдэл 59 хувь буюу дундаж эрсдэлтэй гэсэн ийм үнэлэгдсэн.

Монгол Улс санал болгосон харилцагчийн ашиглаж буй виртуал хөрөнгийн төрөл болон бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн шинж чанар, онцлогийг харгалзсан тус салбарын эмзэг байдлыг үнэлэхэд 61 хувийн эмзэг байдал буюу дундаж түвшний эрсдэлтэй гэж үнэлэгдсэн.

Мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ 85 хувь буюу шинээр үүсэх эрсдэлийг бууруулах удирдах тогтолцоо Монгол Улсад харьцангуй сайн бүрдсэн гэж ингэж үнэлэгдсэн байгаа. Энэ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон холбогдох энэ 13 хуульд нэмэлт, өөрчлөлт орсон, мөн холбогдох 8 журмуудыг бий болгосон гэдэг маань энэ үнэлгээг өндөр гарахад бас ийм түлхэц болсон ийм үзүүлэлт байсан гэдгийг бас энд хэлье гэж бодож байна.

Ингээд Монгол Улс 2020 оны санхүүгийн хориг арга хэмжээ авах энэ байгууллага буюу ФАТФ-ийн энэ жилийн үнэлгээгээр Монгол Улс зөвлөмж 15 буюу виртуал хөрөнгөтэй холбоотой энэ ФАТФ-ийн зөвлөмжүүдийг шат ахиулсан буюу үнэлгээг дийлэнхийг нь биелүүлсэн ийм ФАТФ-ын гишүүн бус анхны улс болсон. Тэгэхээр энэ нь тухайн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзэгчийн тухай хуулийн хэрэгжилт Монгол Улсад бас харьцангуй анхдагч бөгөөд сайн болсон гэдэг энэ бас үнэлгээг олон улсаас өгсөн ийм үнэлгээний нэг хэлбэр байх гэсэн ийм ойлголттой байгаа.

Улмаар Монгол Улс энэ 23 оны үнэлгээгээр ФАТФ-ын 40 зөвлөмжийг дийлэнхийг нь болон бүрэн хэрэгжүүлсэн Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд анхны, дэлхийн хэмжээнд 5 дахь улс болон болсон байгаа.

Мөн энэ зөвлөмж 15-ыг дийлэнхийг нь болон бүрэн хэрэгжүүлсэн дэлхий дээр нийт 32 улс байгаа гэдгийг бас энд хэлье гэж бодож байна.

Хуулийн хэрэгжилтийг хангуулах гол агуулга бол энэ эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгох. Санхүүгийн зохицуулах хорооноос эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлж, хэрэгжүүлж ажиллаж байгаа. ФАТФ-аас өгсөн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх чиглэлийн хяналтад, хяналт шалгалтад эрсдэлд суурилсан байдлаар гүйцэтгэх шаардлагатай гэдэг ийм үндсэн зөвлөмжийг өгдөг. Энэ хүрээндээ хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс зайнаас холбогдох дата мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийсний үндсэн дээр эрсдэлийн цар хүрээг тогтоож, газар дээрх хяналт шалгалтуудыг тогтмол гүйцэтгэж ажиллаж байгаа.

Мөн өөрийн хөгжүүлсэн, Санхүүгийн зохицуулах хорооноос хөгжүүлсэн бодит цагийн горимоор хянадаг арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл болон хэрэглэгчийн тоо, ханшийн мэдээлэл дээр бас энэ хяналтыг рийл таймаар хэрэгжүүлээд ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг хэрэгжилтийг хангах виртуал хөрөнгийн салбарын хяналтыг олон улсын түвшинд нийцүүлэхээр Санхүүгийн зохицуулах хорооноос тодорхой судалгаануудыг хийсэн. Олон улсад ямар төрлийн программ хангамжуудыг энэ салбарт ашиглаж байна вэ гэдэг чиглэлээр. Ингээд олон улсад түгээмэл ашиглагддаг chain analysis гэдэг энэ программын ректор гэдэг программыг үйл ажиллагаандаа ашиглаад явж байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад өмнө цагдаа болон тагнуулын байгууллага Санхүүгийн зохицуулах хороон дээр байдаг. Энэ chain analysis-аар дамжуулаад энэ бүртгэлтэй койнт токенуудын мөрдөх энэ үйл ажиллагаа бас яг энэ дээр бас явдаг гэдгийг бас хэлье. Энэ chain analysis гэдэг энэ блокчэйн суурилсан крипто валютын хяналт шинжилгээ хийдэг энэ компани маань нийт дэлхий даяар 60 гаруй орны зохицуулагч байгууллагууд бас энэ программыг ашигладаг. Тухайн тус системийг ашигласнаар энэ бод...гийн горимоор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн гүйцэтгэсэн виртуал хөрөнгийн арилжаа, гүйлгээ хийсэн дансны мэдээлэл, зэргүүдийг шууд хянах, дүн шинжилгээ хийх, эрсдэлийг үнэлэх, харилцан хамаарлын тогтоох, шаардлагатай тохиолдолд гүйлгээг мөшгөх, хамаарал бүхий хэтэвчүүдийг илрүүл илрүүлэх ийм чиглэлээр энэ программажилладаг байж байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн эрсдэлийг бууруулах энэ олон нийтийг соён гэгээрүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорооны цахим хуудсаар анхааруулга мэдээллүүдийг тасралтгүй бас хүргэж ирсээр байгаа. Сүүлийн жилүүдэд яг энэ цахим гэмт хэрэгтэй холбоотой, мөн цахим гэмт хэргийн нэрийн доор энэ виртуал хөрөнгөтэй холбоотой гэмт хэрэг, ялангуяа мөнгө хуваах терроризмыг санхүүжүүлэх чиглэлийн эрсдэлүүд улам бүүр нэмэгдсээр байгаа. Энэ чиглэлээр холбогдох орон нутагт хуулийг тайлбарлах, таниулах, мөн 21 аймгийн Засаг даргын Тамгын газар болон цагдаагийн хэлтсийн хэлтсүүдэд удаа дараа албан бичиг, санамж, зөвлөмжүүдийг бас хүргүүлж ажилладаг. Энэ хүрээ хүрээнийхээ үйл ажиллагааг хуулийн хэрэгжүүлэлтийг хангуулахаар тасралтгүй хэрэгжүүлж ажилладаг гэдгийг хэлье.

Өмнө хийгдсэн, хууль батлагдахаас өмнө нийт 92 виртуал хөрөнгийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн этгээдүүд бүртгэгчихсэн байдаг. Энд одоогоор хорооны 12 бирж дээр бүртгэлтэй 41 виртуал хөрөнгө, 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, 25 бүртгэлгүй виртуал хөрөнгө, 14 виртуал хөрөнгө, бүртгэлгүй 14 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч гэсэн нийт 92 хуулийн этгээд дээр өмнөх гарал үүсэл нь хаанаас хэд нь хэдий хэмжээний хөрөнгө татсан, юунд зарцуулсан гэдэг талаарх ерөнхий мэдээллүүдийг өөрсдийн авч болох эх сурвалжуудаас цуглуулаад энэ дээр бас дүн шинжилгээ хийгээд Цагдаагийн ерөнхий газарт бас тодорхой албан тоотоор энэ мэдээллүүдийг хүргүүлсэн байж байгаа.

Өөрөөр хэлбэл, урьд өмнө хууль батлагдахаас өмнө Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байсан болон, одоо гарсан байгаа энэ койнтон нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд эдгээр асуудлуудыг эцэслэж, нэгмөр тогтоож өгнө үү гэдэг ийм хүсэлтийг бас Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлж ажилласан байж байгаа. Энэ хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас эдгээр

мэдээлэл дээр үндэслээд бас хяналт шалгалт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаа явагдаж байгаа.

Мөн 24-25 оны Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрын хамтарсан ажлын төлөвлөгөөг баталсан. Үүнд бас виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүллийн салбарыг нэмж, энэ чиглэлийн мэдээ, мэдээллийг солилцох, түгээх, хамтран аж ажиллах энэ үйл ажиллагаагаа илүү нарийвчлан ажиллаж байгаа гэдгийг бас хэлье гэж бодож байна.

Ингээд товч хуулийн хэрэгжилтийг хангуулсан байдлаарх мэдээллийг өгч дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Тэгээд Монгол Улс ямар ч байсан энэ олон улсын ФАТФ-ын зөвлөмжийн дагуу их тийм богино хугацаанд шуурхай ажиллаад суурь хуулиа боловсруулчихсан гэж ойлгож байгаа. Тэр 8 журмууд нь батлагдаад гарсан. Тэгээд ер нь цаашдаа энэ маань ингээд болоод яваад байна уу, яаж сайжруулах вэ гэдэг энэ асуудлыг яриад Улсын Их Хурлын даргын захирамжаар крипто валютын гэдэг нэртэй одоогоор тийм ээ, тэгээд виртуал хөрөнгөтэй холбоотой крипто валюттай холбоотой эрх зүйн орчныг сайжруулах ийм ажлын хэсэг бас гараад ажиллаж байгаа. Тэгээд энэ хүрээнд та бүхнээс мэдээлэл сонсож байна. Дараа дараагийн бас цуврал арга хэмжээнүүд болох байх.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ганбаатар гишүүнээр нэрс тасаллаа. Ганбаатар гишүүний микрофон нээж өгнө үү.

А.Ганбаатар: Нэг зүйлийг л ажлын хэсгээс асууя. Энэ цаана нь бас олон хохирогч олон хүмүүс хохироод байдаг, хохироод байгаа явдал гарч байгаа. Цагдаагийн байгууллага болон хууль хүчний байгууллагаар шийдэж байгаа шийдэл нь хэр оновчтой байгаа юм, хэдэн хувьтай байгаа юм, энэ өөрөө шийдэл мөн юм уу, биш юм уу? Нэгдүгээрт нь.

Хоёрт нь энэ татварын бодлого нь яаж явж байгаа юм? Татвар жирийн бусад аж ахуйн нэгжүүдэд оногдож байгаа татварын систем үйлчилдэг юм уу? Эсвэл архи дарс гэх мэт онцгой татвар оногдуулдаг. ийм зохицуулалт бас үйлчилдэг юм уу? Татвар яаж авдаг юм бол? вдаг юм болов уу үгүй болов уу? Энийг сонирхож байна.

4 номерын микрофон.

Н.Хүдэрчулуун: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Яг Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн түрүүний виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нийт Монгол Улсад бий болсон гээд 92 аж ахуйн нэгжийн хувьд яг таны хэлж байгаа энэ иргэдийг хохироосон ийм асуудлууд байж болзошгүй байна. Энэ дээр тухайн олон нийтээс тодорхой хэмжээний хөрөнгө мөнгө татдаг тэгээд тэрийгээ яг зориулалтын дагуу зарцуулсан уу? Зарцуулалт нь

ямар түвшинд байсан, яг Монгол Улс дээр жишээ нь энэ гаргасан 66 койн токны асуудал яригдаж байгаа. Тэгээд бид нарын авч байгаа мэдээллээр энэ болохоор албан бус мэдээллүүд байгаад байдаг.

Өөрөөр хэлбэл, тухайн койн ток нь гаргагч би 30 тэрбумыг татна, амжилттай боллоо гэдэг мэдээллийг л сошиалд өгдөг. Яг тухайн санхүүгийнүйл ажиллагаатай холбоотой нарийн мэдээллийг нь Санхүүгийн зохицуулах хороо шууд авах ийм боломж бүрддэггүй.

Тийм учраас яг энэ татагдсан хэмжээгээрээ гэж үзэх юм бол Монгол улсад энэ 66 койн токны хувьд 980 орчим тэрбумын хөрөнгийг татсан байж болзошгүй байна гэдэг бид нарын урьдчилсан ийм тоогоор.

Тэгэхдээ энэ бол зөвхөн тухайн койн токныг эзэмшигч нь бид нар ийм хэмжээний 5 тэрбумыг татах байсан, энэ нь амжилттай боллоо гэсэн энэ мэдээлэл дээр л үндэслэж гаргаж ирж байгаа тоо. Тэгэхээр энийг бас Цагдаагийн ерөнхий газраас энэ үйл ажиллагааг яг шалгаад яг олон нийтээс хэчнээн төгрөг зарцуулсан, юунд зарцуулагдсан байна, энэ нь яг зориулалтын дагуу зарцуулагдсан уу гэдгийг шалгаж өгөөч ээ гэдэг энэ агуулгаар саяын үйл ажиллагаа хийгдсэн гэдгийг хэлье.

Нөгөө талаасаа өөр байдлаар тухайн энэ хуулийн зохицуулалтын хүрээнд хохирогч болсон тохиолдолд цагдаа шалгахаас өөрөөр төр хариуцах ямар нэгэн зохицуулалт энэ хуулийн үйлчлэлийн хүрээнд байхгүй байгаа гэдгийг хэлье.

Татварын хувьд ердийн горимоор яг Монгол Улсын та ямар нэгэн хөнгөлөлт чөлөөлөлтгүйгээр татварын хууль тогтоомжийн дагуу татвараа төлөх үүргийг энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид хүлээж байгаа.

Ж.Золжаргал: Хүдэрчулуун даргаас тодруулаад асуучих уу? Тэр 91 юу гарсан гэсэн шүү дээ 92 аж ахуйн нэгж дээр дүн шинжилгээ хийсэн гээд. Тэгээд Цагдаагийн ерөнхий газар шилжүүлсэн тэндээс тэдэн ширхэгингээд шийдвэр гарсан тийм тохиолдлууд байна уу, та бүхэнд мэдээлэл буцаж ирсэн үү?

Н.Хүдэрчулуун: Өнөөдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд энэ хэргийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг Цагдаагийн ерөнхий газраас өгөөгүй байгаа. Хороо тухайн мөрдөгдөж байгаа хэргүүдийн хувьд шинжээчээр, бас шинжээч болон гэрчийн мэдүүлэг өгөөд хамтарч бас ажиллаж байгаа. Тэгээд тодорхой хэсгүүд нь бас мөрдөн байцаалтын нууц байгаа учраас энэ талын зарим мэдээллүүдийг бол прокурорын зөвшөөрөлтэй дэлгэж болно гэсэн ийм мэдээллийг бас цагдаагаас өгсөн байгаа.

Ж.Золжаргал: Ойлголоо Соронзонболд гишүүний микрофоныг нээж өгнө үү Соронзонболд гишүүний микрофон.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Маргааш манай крипто валютын зохицуулалттай холбоотой судлах ажлын хэсэг маань 10-аас Сүхбаатарын танхимд хуралтай байгаа. Тэгэхээр би Санхүүгийн зохицуулах хорооноос маргааш юу хүлээж байгаа вэ гэхээр маргаашийн танилцуулга бол энэнээс арай өргөн хүрээтэй, цаашдаа бид нар юуг, ямар ажлууд хийх ёстой байгаа юм бэ? Ямар арга хэмжээ шаардлагатай байна, ямар хууль, эрх зүйн

орчинд өөрчлөлт оруулахтай байна энэ талаасаа илүү Санхүүгийн зохицуулах хорооноос ийм саналтай орж ирэх байх гэж найдаж байгаа.

Тийм учраас би зүгээр маргаашийн хурлын талаар зүгээр бэлтгэл болгож асууж байгаа шүү. Тэр талаар мэдээлэл өгвөл сайн байна.

Ж.Золжаргал: 4 номерын микрофон Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд энэ хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангуулсан талаарх мэдээллийг өг гэсэн учраас яг энэ хүрээндээ танилцуулгыг бэлдлээ.

Маргааш бол ерөнхийдөө зах зээл болон хуулийн хэрэгжилт ямар байсан илүү дэлгэрэнгүй мэдээллийг өгөхөөр Санхүүгийн зохицуулах хорооноос ажиллаж байгаа болно гэдгийг хэлье. Баярлалаа.

Ж.Золжаргал: Ундрам гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ч.Ундрам: Энэ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг өнгөрсөн парламентад бид нар баталсан. Тэгээд яг энэ хуулийг батлах болсон шалтгаан нь маш олон янзын койн гарч ирээд бүүр ингээд спекуляц болоод байсан. Хүмүүс маш ихээр хувийн хөрөнгөө өмчөө зараад ийшийгээ хөрөнгө оруулалтууд хийгээд нэг л ингээд мөнгө нь зүв зүгээр байж байгаад л өсөх юм шиг ийм нөхцөл байдал үүссэн уч бас бид нар 21 оны 12 сарын 17-нд хууль баталсан байгаа.

Тэгэхдээ бас тодорхой хэмжээгээр нэлээн оройтож энэ хуулийг баталсан юм шиг санагдаж байгаа. Маш олон иргэд хохирсон. Тэгээд сая бас ярьж байна 92 байгууллагыг цагдаад өгсөн гээд тэгж байна. Эндээс хамгийн хэл амтай олон нийтийн анхаарлыг татсан Ай Эйч Си Койн гээд байгаа тээ? Энэ яг тодорхой энэ койноос болж маш олон хүмүүс хохирсон байгаа. Тэгэхээр яг энэ койны асуудал ямар шатандаа явж байгаа вэ? Энэ шийдэгдсэн үү? Энэ нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт, энэ аудитын 6 компани сонгогдоод тэгээд хуулийнхаа дагуу аудит хийж байгаа юм байна. Тэгэхээр аудит хийгээд ямархуу дүр төрхтэй энэ бүртгэгдсэн компаниуд нь алдаа дутагдал байна уу, үгүй юу? Хэрвээ алдаа дутагдал гарсан бол ямар төрлийн асуудлууд энэ компаниуд дээр гарч байгаа вэ гэдэг хоёрдугаар асуудал байна.

Гуравдугаарт, эрсдэлийн үнэлгээ хийсэн байна. Тэгээд 59 хувийн ийм үнэлгээтэй үнэлгээний дүнтэй байна гэж байна л даа. Тэгэхээр энэ бол хангалттай хувь биш гэж би үзээд байна. Тэгэхээр цаашид та хэд энэ эрсдэлээ улам бууруулах, эрсдэл нь буурахаар бодвол үнэлгээ нь дээшээ явна. Тэгэхээр энэ чиглэлээр ямар ажил хийе гэж төлөвлөж байна. Энэ хууль, эрх зүйн орчин одоо байгаа нь хангалттай гэж үзэж байна уу, үгүй юу? Эсвэл өшөө дахиад сайжруулах хэрэгтэй юу гэдэг дээр түрүүн бас Байнгын хорооны дарга халт асуух шиг болсон.

Мөн энэ хяналт зайнхяналт шалгалт хийдэг Чэйн анализис хяналтын систем авсан байгаа тээ? Энэ системээ та хэд ер нь хэр ажиллуулж байна? Энэ чинь виртуал хөрөнгийн урсгалыг мөшгөх гээд л олон ийм юманд чинь хяналт тавихад хэрэгтэй байгаа шүү дээ. Энийг хэр ашиглаж байна? Энийг ашиглаад ямар үр дүн гарсан бэ гэсэн ийм асуултууд байна.

Ж.Золжаргал: 4 номерын микрофон нээж өгнө үү.

Н.Хүдэрчулуун: Ундрам гишүүний асуултад хариулъя.

Энэ анх хууль маань 2021 оны 5 сард анх Улсын Их Хуралд өргөн баригдаад 12 сарын 17-нд батлагдсан байгаа. Тэгээд энэ хугацаанд анх 5 сард өргөн баригдаж байхад Монгол Улсад 2 койн, 2 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч л үйл ажиллагаа явуулж байсан. Тэгээд хууль маань бас энэ Улсын Их Хурлаар хэлэлцэх явцдаа бас тодорхой хэлэлцүүлгүүдийг дамжих ийм шаардлага гарсан. Тэгээд энэ хугацаанд, явах хугацаанд, хууль батлагдах хүртэл хугацаанд нийт 66 койн, 24 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байсан. Тэгээд бид нар энэ хууль гарснаар урьд өмнө байсан үйл ажиллагааг нөхөж энэ хууль үйлчлэх боломжгүй учраас яг зөвхөн зарцуулалтынх нь хувьд энэ яг олон нийтэд татсан хөрөнгийг тухайн вайт... байдаг юм уу, тухайн бод баримт бичгүүд дээр тусгагдсан зориулалтынхаа дагуу зарцуулсан эсэх, яг олон нийтээс яг хэчнээн төгрөгийн хөрөнгийг татсан юм гэдэг энэ мэдээллүүдийг бас нэгтгэх зорилгоор энэ саяын хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулсан байж байгаа. Энд татвар, Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн мэдээллийн алба гээд төрийн бус байгууллагуудыг оролцуулаад цагдаагийн байгууллагуудыг оролцуулсан ийм ажлын хэсэг байгуулаад энэ ажлын хэсгийг Санхүүгийн зохицуулахаараа ахлаад ажиллаад Цагдаагийн ерөнхий газарт эдгээрүүдийг бүгдийг нь шалгах шаардлагатай байна гэдэг ийм дүгнэлтэд хүрээд хүлээлгэж өгсөн байдаг.

Яг Ай Ти Си гэдэг энэ койны хувьд бол шууд мөрдөн байцаалтын явц нь тийм байгаа гэдэг мэдээллийг өгөх боломж алга байна. Өөрөөр хэлбэл Цагдаагийн ерөнхий газар дээр мөрдөн байцаалтын явц үргэлжилж байгаа учраас энэ бас хуулиараа бас тодорхой мэдээллүүдийг гаргах боломжгүй байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос яг энэ хэрэг дээр бас шинжээч болон гэрчийн мэдүүлэг өгч ажиллаж байгаа гэдэг мэдээллийг өгөх боломжтой байна.

Аудит хийх хуулийн этгээдийг Хороо тодорхой сургалт, мэдээллүүдээр хангаад эдгээрт энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр хийгдэх аудитын санхүүгийн аудит хийх энэ эрхийг нь бүртгэлжүүлж байгаа. Үүнээс тусгай зөвшөөрөл олгож байгаа биш илүү мэргэжлийн түвшинд энэ виртуал хөрөнгөтэй холбоотой харилцаанд аудит хийх энэ бүртгэлийг л хий гэж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ 12 бирж маань энэ хороонд бүртгэгдсэн 6 аудитын компаниар л санхүүгийнхээ аудитыг хийлгэх боломж энэ хуулиар олгогдсон. Одоогийн байдлаар яг ноцтой, нийтлэг аудитын ийм алдаа дутагдал гэхээсээ илүү тухайн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллүүд дээр бас хангалттай сайн тийм тайлбарууд байхгүй байна гэсэн ийм ерөнхий дүр зургууд гарч байгаа.

Таны яг хэлсэн энэ эрсдэлийн үнэлгээ 59 хувь гэдэг хангалттай биш ээ гэдэг дээр санал нэг байна. Өөрөөр хэлбэл, энэний гол суурь мөн чанар нь тухайн виртуал хөрөнгийн өөрийнх нь суурь мөн чанар бол энэ эрсдэл маш өндөртэй ийм зүйл учраас энэ эрсдэлийг бол 59 хувь буюу дундаж гэдэг энэ үнэлгээ дээр гарч ирж байгаа.

Харин Монгол Улсад энэ эрсдэлийг бууруулах энэ арга хэмжээ хууль тогтоомж, дүрэм, журам эдгээрүүд нь бас хангалттай сайн бүрдсэн нь энэ

эрсдэлийг бууруулах нэг гол механизм болж байна гэдэг ийм дүгнэлт үнэлгээ гарсан байгаа юм. Яг энэ эрсдэл дээр суурилоод одоо 2 дахь шатын энэ виртуал хөрөнгийн эрсдэлийн үнэлгээг Монгол Улс хийх, хэрэгжүүлэх ийм шаардлага хэрэгцээ тулгарч байгаа. 28 онд ФАТФ-аас Энэ Монгол Улс дараагийн шатын харилцан үнэлгээндээ орох ийм хүлээлттэй байж байгаа. Тэнд энэ үнэлгээнд энэ виртуал хөрөнгийн.../минут дуусав./

Ж.Золжаргал: 4 номерын микрофон нэмэлт хугацаа өгье.

Н.Хүдэрчулуун: Уучлаарай энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзэлд шинэ тухай хууль батлагдсанаар бас Төрийн албаны тухай хуульд бас дагаж нэмэлт, өөрчлөлт орсон байж байгаа. Өөрөөр хэлбэл, Санхүүгийн зохицуулах хороонд Засгийн газар тодорхой квотоор төрийн цалингийн итгэлцлүүдээс гадуур 5 хүртэл тооны Ай Ти нарийн мэргэжлийн ийм ажилтныг ажиллуулах боломжийг бас энэ хуулийг дагалдуулж бас нээж өгсөн гэж. Яг бодит амьдрал дээр яг энэ маань бас яг төдийлөн сайн хэрэгжиж чадахгүй байгаа. Өөрөөр хэлбэл, өндөр түвшний Ай Ти-гийн мэргэжилтнүүд маань тухайн цалингийн шатлалыг бас тодорхой үржүүлэгчээр нэмж өгсөн ч гэсэн төрийн албаны тодорхой ангилал, зэрэглэл байхгүй үйлчилгээний төрийн албанд ажилласан зэрэг, дэв, цол бусад хангамжууд нь ингээд хасагдчихдаг учраас энэ дээр бас яг ажиллах сонирхолтой ийм.../минут дуусав./

Ж.Золжаргал: Ундром гишүүнээ нэмээд нэмээд асуучих уу даа тодотгоод, тэгээд асуултаа дараа гүйцэд авчихъя. Тийм Ундром гишүүний микрофон.

Ч.Ундром: Энэ аудитаар хөрөнгийн зарцуулалтын талаар тодорхой биш байна гээд нийтлэг ийм дүгнэлт гарч байна гэдэг чинь л аймаар бүрхэг том эрсдэл харагдаад байна л даа. Хүмүүсээс баахан койн зараад мөнгө босгочихдог тэгээд тэрийгээ хамаа намаагүй үрж байна л гэсэн үг шүү дээ. Энэ чинь хамгийн том, хамгийн аюултай дүгнэлт байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр та хэд ажиллах ёстой гэж би бодож байна цаашид.

5 мэргэжилтэн тэгээд энэ chain analysis гээд ийм мундаг программ авчихсан тэгээд 5 хүн байхгүй болохоор ингээд сайхан программ хэвтэж байгаа юм байна шүү дээ тээ. Тэгэхээр энэ дээрээ та хэд бас тэр Төрийн албаны зөвлөлтэй яриад өшөө энэ Байнгын хороо юу байдаг юм засагтайгаа яриад хүнээ авахын тулд тэр зэрэг дэвийг нь зөв болгоод, цалингийн шатлалыг нь зөв болгоод төсвөөс өмнө ингээд сууж байх ёстой байхгүй юу өнөөдөр. Тэгэхээр энэ дээрээ анхаармаар байна.

Ж.Золжаргал: 4 номер.

Н.Хүдэрчулуун: Ундром гишүүний хэлж байгаа саналтай санал нэг байна. Өөрөөр хэлбэл, яг энэ агуулгын хүрээнд энэ мэдээллүүдийг нээлттэй, ил тод, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхээр тавих шаардлагуудыг хорооноос хүргүүлж байгаа. Тухайн койныг шууд зохицуулах ийм харилцаа хороонд үүсэхгүй байгаа. Өөрөөр хэлбэл, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч маань тухайн койн, токены тэр тайлан, мэдээллүүдийг өөрийнхөө веб сайт тэр бусад холбогдох мэдээллүүд дээр ил тод нээлттэй байлга гэдэг шаардлагуудыг хороо байнга өгч явж байгаа. Тэрийг хангуулахын тулд тодорхой хугацаатай үүрэг даалгавар, санамжуудыг өгөөд ингээд ажилладаг гэдгийг бас танд хэлье.

Хяналтч мэргэжилтнийг Ай Ти-гийн өндөр мэргэжлийн хүмүүсийг авч чадаагүй гээд зүгээр суугаагүй, өөрсдийн нөөц бололцоогоо ашиглаад тодорхой энэ чэйн анализаас тодорхой сургалтууд байдаг. Энэ сургалтуудад тогтмол хамрагдаад бас ажиллуулаад.../минут дуусав./

Ж.Золжаргал: Ундрам гишүүний хэлдэг коммент ер нь энд тэнд бас их тулгамдсан тэгээд л хаа сайгүй л бас л байгаад байна л даа. Гоё систем нэвтрүүлчихсэн тэрийгээ бүрэн ашиглаж чаддаггүй. Энэ дээр та бүхэн анхаарна биз.

Нэмэлт асуулт байна. Одоо хуулиараа Монгол Улсад бүртгүүлээд тэгээд үйл ажиллагаа явуулах ёстой. Тэгэхдээ олон улсын ийм виртуал хөрөнгийн биржүүд бүртгэлгүй тэгээд гүйлгээ хийгдээд яваад байгаа юм. Энийг ер нь та бүхний бодлоор яах ёстой вэ? Бид нар хуулиа мөрдүүлээд, бүртгэлгүй бол хаах ёстой юм уу? Эс үгүй бол эрх зүйн орчинд өөрчлөлт оруулж жоохон уян хатан болох ёстой юм уу? Тэр дээр байр суурь, бодол сонсмоор байна.

Хоёрдугаарт нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд нягтлан бодох бүртгэлийн ийм үлгэрчилсэн загваргүй байгаад байгаа юм. Тэгээд тэр загварыг боловсруулах шаардлагатай байна гээд бид бичиг явуулсан. Энд ажлын прогресс хэр байгаа бол?

Гуравдугаарт нь одоо яах вэ нэг ийм том давлагаа гарч ирээд арай намжчихсан. Тэгэхдээ ер нь цаашдаа мэдээж дахиад л янз бүрийн виртуал хөрөнгө, койн, элдэв янзын юм гарч ирж таарна. Тэгэхээр тэр болгон дээр нэг талаасаа үр ашгийг нь таниулах, нөгөө талдаа эрсдэлийг нь таниулах тийм олон нийтэд зориулсан яг бүртгэлтэй мэргэжлийн байгууллагууд биш ийм мэдээллийг танай зүгээс бэлдэж ажиллаж байсан, ажиллаж байгаа тийм зүйл бий юу, чиг үүрэгт нь хамаарах уу? Энэ талаар.

4 номер.

Н.Хүдэрчулуун: Золжаргал гишүүний асуултад хариулъя. Яг Монгол Улсад үйлчилж байгаа энэ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль бол энэ дотоодод гарч байгаа койнуудын зохицуулалт л хийгдэж байгаа. Ийм онцлогтой зохицуулалт байж байгаа.

Таны яг санаа зовж байгаа энэ зохицуулалтыг яг дэлхий нийтээрээ шийдсэн улс орон алга. Монгол Улс энэ ФАТФ-ын гишүүн орнуудын хувьд энэ виртуал хөрөнгийн чиглэлээр яг таны яг энэ олон улсад гарч байгаа энэ хил хязгааргүй энэ койн токенууд, энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлчдийг хэрхэн яаж зохицуулах вэ гэдэг энэ чиглэл дээр ФАТФ-аас бас ийм тодорхой бодлогын ийм бүлэг гараад ажиллаж байгаа. Монгол Улс энэ Ази-Номхон далайн бүлэгт багтдаг нийт 47 улс энд харьяалалтай байдаг. Эндээс Ази-Номхон далайн бүсийн нарийн бичиг нь Монгол Улс төлөөлөөд ФАТФ энэ виртуал хөрөнгөтэй энэ харилцааг хэрхэн яаж зохицуулах вэ гэдэг бодлогын зөвлөмжийг боловсруулах ажлын хэсэгт бас Монгол Улс Ази-Номхон далайн бүсийг төлөөлөөд ажилладаг болсон энэ жилээс. Тэгэхээр эндээс бас тодорхой бодлогын зөвлөмжүүд ч гарч байна, вай...гэдэг юм уу бусад энэ хил хязгааргүй энэ wallet эдгээрийг ямар нэгдсэн зохицуулалттай байлгах боломжтой гэдэг ийм санал, дүгнэлтүүдийг гаргах ийм ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Энд Монгол Улсаас Санхүүгийн зохицуулах хорооноос төлөөлөөд ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Тэр нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал энэ Сангийн яамны яг шууд бүрэн эрхэд хамаардаг. Өөрөөр хэлбэл, нягтлан бодох бүртгэлийн тэр заавар, дүрэм, журмуудыг боловсруулах эрх нь Сангийн яаманд байдаг.

Сангийн яаманд Санхүүгийн зохицуулах хорооноос энэ чиглэлийн энэ заавар, зөвлөмжүүдийг баталж өгөөч гэдэг ийм хүсэлтүүдээ хүргүүлсэн ингээд ажиллаж байгаа.

Олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг Санхүүгийн зохицуулах хороо 20 оноос хууль батлагдахаас өмнө, хууль батлагдсанаас хойш тасралтгүй байнга зохион байгуулж явж байгаа.

Тухайлбал, 20, нийт 15 аймагт энэ хуулийн хэрэгжилт болон койн, токинг энэ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хэн юм энэний цаана ямар эрсдэлүүд байдаг талаарх сургалт сурталчилгаануудыг бол хийж ажилладаг. Энэ бас хорооны үндсэн басчиг үүргийн нэг мөн.

Нөгөө талаасаа Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд энэ санхүүгийн боловсролыг олон нийтэд хүргэх энэ ажлыг зохион байгуулах чиг үүрэг бас Санхүүгийн зохицуулах хороонд байдаг гэдгийг хэлье.

Ж.Золжаргал: Баярлалаа. Та бүхэн тэр ФАТФ-ын ажлын хэсэг дээр ажиллаж байгаа байж болох шийдлийн талаар маргааш ажлын хэсэг дээр танилцуулга хийхдээ бас дэлгэрэнгүй мэдээлэл өгвөл сайн байна. Ямар боломжит хувилбарууд байх вэ гэдгийг энийг анхаарна биз.

Энэ асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд байна уу?

Үг хэлэх гишүүн байхгүй байна.

Ингээд гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэлж, асуулт асууж дууслаа.

Ажлын хэсэгтээ баярлалаа.

15.37 цаг

Одоо хэлэлцэх асуудал хоёр. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох ийм асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийнхнийг урьж байна. Ажлын хэсгийн танилцуулъя.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Үндэсний хороо давхар хуралдаж байгаа учраас ирэх боломжгүй байна гээд мэдээлсэн байгаа. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Алтан-Од, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Золбаяр, Цахим хөгжил, инноцвац, харилцаа холбооны сайдын зөвлөх Тулгат, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Бат-Өлзий, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга Батбаатар, И-Монгол академийн захирал Мягмарнаран, Үндэсний дата төвийн захирал Баттулга, Кибер халдлага,

зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирал Жавхлан ирсэн байна. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга Батбаяр, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч Болор-Эрдэнэ, Салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч Энхтулга, Дэмжих систем хариуцсан шинжээч Отгонбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой гишүүд асуулт асуухаас өмнө ер нь зүгээр зорилгын талаар та бүхэндээ бас бодол, мэдээлэл хуваалцъя. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гээд тэгээд энэ хууль дээр холбоотой хэд хэдэн ийм чухал зүйлс байгаа юм.

Нэгдүгээрт нь энэ 8 дугаар зүйл дээр нээлттэй мэдээлэл тэгээд энэ бол ингээд бидний мэдэхийн тэр хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, өргөдөл гомдлын тайлан мэдээ ингээд л ажлын байр, албан хаагч, тэгээд төслийн гүйцэтгэлийн биелэлт, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан гэх мэтчилэн жагсаасан нийтдээ 68 ийм нийтэд нээлттэй байх ёстой мэдээллүүд байдаг. Энэ мэдээллүүд нээлттэй байж чадаж байгаа юу, үгүй юу гэдэг нэг айхтар асуулт байгаа.

Хоёрдугаарт нь өнгөрсөн хугацаанд төрийн байгууллагуудын энэ 14 жилийн надад ирсэн мэдээллээр нийтдээ ойролцоогоор 2 их наяд төгрөгийн цахим системүүд, программ хангамжууд худалдаж авсан байгаа 2014-24 оны хооронд. Тэгээд энийг задаргааг албан бичгээр өгөөч гээд би яам руу Байнгын хорооноос бичиг явуулаад байгаа юм. Хариу ирэхгүй байгаад байгаа юм. Энэ нь ингээд нийт дүнгээрээ гадаадаас 205 сая доллар, дотооддоо 1.5 их наяд төгрөгийн ийм дүнтэй тэгээд ингээд энэ 22 онд хийсэн тийм судалгаа байна лээ л дээ 9 дүгээр сард 24 оныг дуустал. Тэгээд зарим нь ингээд шаардлагатай, зарим ньшаардлагагүй ийм зүйлс байна гээд. Энэ бол ямар ч байсан нэлээн ингэж цэгцэлж ийм тооцоо, үндэслэл гаргаж байсан юм байна. Тэгэхээр одоо энэ ажлыг шинэчилсэн үү?

Ер нь цаашдаа энийг ингээд үр ашигтай зарцуулах шаардлагагүй цахим системүүдийг хийхгүй байхын тулд энэ хуулийн 29 дүгээр заалт тэр зохицуулалт бол гарсан байдаг. 29 дүгээр заалт дээр энэ зөвлөмжүүдийг яамнаас авах ёстой. Тэр зөвлөмжүүд юу болж байна вэ гээд Байнгын хорооноос бас бичиг явуулаад 17 байгууллагууд руу энэ 24, 25 оны төсвийн хүрээнд бид нар явуулаад ингээд заримаас нь хариу авсан. Ийм байдалтай байж байгаа. Тэгэхээр энэ цаашид энийг яаж хэрэгжүүлэх вэ гэдэг нэг асуудал байна. Мэдээллийн эзний зөвшөөрлийн харилцаатай холбоотой ягажил явуулж байгаа хүмүүст бас тулгамдаад байдаг давхар давхар зөвшөөрөл авахуулдаг, эс үгүй бол эсрэгээрээ хуулийн заалт нь биелдэггүй иймэрхүү асуудал бас ирж байгаа. Тэгээд нийтийн мэдээллийг ашиглах эрхтэй холбоотой мэдээлэл өгөгдөл болгож цахим системүүд, хиймэл оюун, янз бүрийн хөгжлийн юманд ашиглах ийм боломжийг хэрхэн нээх вэ гэх мэтчилэн иймэрхүү асуудлууд байгаа. Тэгэхээр энэ хүрээг та бүхэн бас танилцуулга хийхдээ анхаараасай гэж бодоод урьдчилаад танилцуулж байгаа юм.

Танилцуулгыг Төрийн нарийн бичгийн дарга Алтан-Од хийх үү ?Алтан-Од дарга танилцуулга хийнэ. Баярлалаа. 6 номерын микрофон нээж өгөөрэй.

П.Алтан-Од: Байнгын хорооны дарга эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэдээллийг яам болоод харьяа салбар байгууллагын хүрээнд бэлдсэн мэдээллийг хүргэе.

Цахим хөгжлийн индексүүд сайжирч байгаа гээд энэ оноос индексүүдийн олон улсын судалгаанууд гарсан. Монгол Улс Засгийн газрын санаачилга, хувийн хэвшлийн амжилт, иргэдийн оролцооны үр дүн дээр НҮБ-аас эрхлэн гаргадаг цахим засаглалын хөгжлийн индексээр 28 байр урагшилж, 46 дугаарт эрэмбэлэгдсэн байгаа.

2020, слайд дээр харагдаж байна 2020-24 оны индексийн үзүүлэлтүүдийг дэлгэцэд харуулж байна. Төрийн цахим үйлчилгээний индекс нь 0.53 хувьтай 20 онд байсан бол 24 онд дэлхийн дунджаар 0.82 гэсэн үзүүлэлттэйгээр. Энэ гол индексүүд энэ 3 ар талын чартерт харуулчихсан байгаа хэсэг дээр бол энэ индекс нь ер нь юу юуг дотроо агуулж үзүүлэлтүүд нь нэгтгэж гардаг юм бэ гэдэг танилцуулга гарч байгаа.

Хоёрдугаарт, харилцаа холбооны дэд бүтцийнх нь асуудал ямар байна вэ гэдгийг улс орон болгоноор нь харуулдаг. Энэ нь 2020 онд 0.61 байсан бол дэлхийн дунджаас 0.93 болж манайх өссөн. Хүний нөөцийн чадавхын индекс 0.81 байсан бол 24 оны байдлаар 0.77 болж өссөн.

Цахим хөгжлийг дэмжих багц 4 хуулийг 2022 оны 5 сарын 1-нээс хэрэгжиж эхлэхээр батлагдсан дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулиуд батлагдаж мөрдөгдөж байгаа. Цахим шилжилтийг эрчимжүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулсан 109 хуулийн өөрчлөлтийг 2023 оны 5 сарын 15-ны өдрөөр баталж өгсөн.

Хуульд туссан төрийн цахим үйл ажиллагааны зарчмууд нь бол уялдаатай байх гол зарчим байдаг. Мэдээлэл нь энэ зөрөхгүй байх, давхардалгүй байх, хоёрдугаарт ой санамжтай байх асуудал, зарчим туссан байдаг бол энэ нь төрд байгаа мэдээллийг иргэнээс, хувийн хэвшлээс дахин шаардахгүй байхаар зохицуулалт агуулсан.

Цаасгүй байх асуудал байдаг. Цахим хэлбэрт шилжиж цаасан бичиг баримттай эн тэнцүү үйлчлэх хуулийн үйлчлэл зарчимд болж туссан.

Нэгдмэл төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ерөнхийдөө бүрдүүлэхээр энэ хуулийн зарчмууд оршино. Хуулийг зохицуу зохицуулж байгаа харилцаагаар нь харах юм бол нийтийн мэдээлэл нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл гэж орж ирж байгаа. Энэ дээр тодорхой хэлэх юм бол shilen.gov.mn, eopendata.gov.mn, sudalгаа.gov.mn гэсэн хаягуудыг домэйнүүдыг оруулж болно.

Үндсэн болон дэмжих систем мэдээлэл хариуцагчийн систем гэж хурдан систем, И-Монгол, docx гээд ингээд системүүдийг нэрлэж болно.

Суурь болон төрөлжсөн мэдээллийн системүүд дээр улсын бүртгэлийн болоод газрын бүртгэлийн мэдээллийн сангуудыг хэлнэ. Нийтийн мэдээллийн дэд бүтэц, систем ашиглалт төрийн үйл ажиллагааны цахимаар явуулах, төрийн

үйлчилгээ үзүүлэх портал сайт хувийн хэвшлийн байгууллагуудын тоо, байгууллагын тоо бол 87, үйлчилгээний тоо нь 1258 байгаа.

Мэдээллийн эзний зөвшөөрөл мэдэгдэл хүргэх буюу нотификэйшн хүргэдэг нь бас энэ систем байгаа. Мэдээлэл хариу хариуцагч төрийн байгууллага, төрийн нэрийн өмнөөс чиг үүрэг хэрэгжүүлж байгаа байгууллагыг мэдээлэл хариуцагч гэж тодорхойлж өгсөн байгаа.

Хуулийн хамрах хүрээн дээр 1 дүгээр хэсэг дээр мэдээллийн ил тод байдлыг бүлэглэсэн. 2 дугаар хэсэг дээр нийтийн мэдээллийн дэд бүтцийн асуудлыг бүлэг болгож оруулсан. 3 дугаарт төрийн цахим үйл ажиллагааны гэсэн гол хэсгүүдэд хувааж үзнэ.

Нийтийн мэдээллийн ил тод байдал дээр бол shilen.gov.mn², opendata.gov.mn², gov.mn одоо нийтийн мэдээллийн системийг төрийн байгууллагуудаас мэдээллээ нэгтгэж хүлээж авч, санал, зөвлөмж хүргэх Золоо даргын, Золжаргал даргын бас санаачилга энэ намар бас бид нар төсөв хэлэлцэж байх үед ярьж байсан бол бодитой ингэж цахимаар хүлээж авч хянадаг процессыг мөн яам эхлүүлсэн байгаа.

sudalгаа.gov.mn гээд нийтийн мэдээллийн ил тод байдлыг ингэж хангахаар ажиллаж байна. shilen.gov.mn 2 хиймэл оюун ухаанд суурилсан ашиг малтмалын тусгай зөвшөөрлий, нингээд дэлгэц дээр харуулсан мэдээллүүд дээр энэхүү хиймэл оюун ухаан зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг нээлттэй мэдээллээр сунгагдсан, сургагдсан болно гэдгээр ингээд агуулж байгаа.

Байршуулсан мэдээллийн тоо 970335, хандалтын тоо 15 сая давсан байж байгаа. Мэдээлэл оруулсан байгууллага нь бол ер нь 5000 орчим мэд байгууллага мэдээлэл оруулах ёстойгоос 172 орчим байгууллага мэдээллээ оруулж явж байна. Нийт мэдээлэл хариуцагч байгууллага нь 1059 байгууллага, хүн томилогдож ажиллаж байгаагаас хандах эрхтэй 1230 албан хаагч одоогоор идэвхтэй хандаж мэдээллээ оруулж явж байгаа.

Энэ хуулийн бас зайлшгүй бас нэг гол хэсэг болох шилэн ажиллагааны асуудал яригддаг. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, төрийн байгууллагуудын индексийн асуудал, шилэн индексийн хувь ямар хэмжээнд явж байгаа вэ гэдгийг бас ингэж эрэмбэлдэг хувь үзүүлэлтээр нь төрийн байгууллагуудыг гаргадаг байгаа. Ингээд нийт 172 байгууллагын үнэлгээний дундаж нь 77.2 хувьтай гэдгээр гарсан байгаа. Одоогийн байдлаар 970355 нэгжийн мэдээллийг байршуулсан. Өмнө дурдсан 15 орчим сая хандалт авсан бас ингээд тодорхой хэмжээний хэрэглэгчдийн ашигладаг ийм систем болсон байна.

Энэ дээр 5 чиглэлийн 68 төрлийн мэдээллийг агуулж байгаа. Чиг үүрэг, үйл ажиллагаа, стратеги, зохион байгуулалтын асуудал, 2 дугаарт хүний нөөцийн асуудал, 3 дугаарт төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлын асуудал, 4 дүгээрт иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээ, эцэст нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний бусад мэдээллийг оруулахаар зохицуулсан байдаг.

Нийтийн мэдээллийн дэд бүтэц болон үндсэн болон дэмжих системүүдийн асуудлыг дэлгэц рүү өгье. Тус хуулийн 18 дугаар зүйл дээр нийтийн мэдээллийн дэд бүтэц дээр бол үндсэн систем, суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас

мэдээллийг төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд ашиглах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн төрийн мэдээллийн солилцооны системүүдтэй байхаар заасан. Ингээд Хур, дан систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, И-Монголиаи, И Ар Пи бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн лавлагаа монголиа, e-cabinet.gov.mn Засгийн газрын opendata.gov, docx.gov.mn, тоон гарын үсгийн систем, и-бизнес гээд гэх мэтчилэн үндсэн болон дэмжих ситемүүд байгаа.

Төрийн цахим үйл ажиллагаа, дараагийн слайдыг үзүүлье. Төрийн цахим үйл ажиллагааны систем дээр И-Монголиа дээр үйлчилгээ үзүүлсэн тоо манайхан жоохон бодитойгоор ер нь яаж төсөвт хэмнэлт үзүүлж байгаа юм бэ гэдэг дээр, цахимжснаараа ямар үр дүнг авчирч байгаа юм бэ гэдэг тоон мэдээллийг гаргаж үзүүлсэн байгаа. Ингээд үйлчилгээ үзүүлсэн тоо маань 29 сая давсан байгаа. Төрийн байгууллага руу ирэх, буцах зардал дээр иргэд, хувийн хэвшил, бусад этгээдүүд дээр 95 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт тодорхой үүсжээ гэж, бичиг цаасны зардал дээр 1 тэрбум орчим төгрөгийн бодитой зардал үүссэн. Үйлчилгээ авахад зарцуулсан хугацаа 165 арван, 65 тэрбум орчим төгрөгийн ингээд боломжийг, хэмнэлтийг иргэдэд хувийн хэвшилд үзүүлсэн гээд. Нийтдээ бол энэ төрийн цахим үйл ажиллагаа И-Монголиа нэвтэрснээр 262 орчим тэрбум төгрөгийн хэмнэлтийг үйлчилгээ авах иргэдэд төрийн хувийн хэвшлийнхэнд үзүүлжээ гэж судалгаа гарсан байна.

Нийтийн мэдээлэл үүсгэхийн өмнө үйл явц, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхөөр Байнгын хорооны гишүүд маань өмнөх хуралдаан дээр бас сануулж байсан. Ингээд төсөв хэлэлцэх үед манай яамнаас тодорхой хэмжээний тооцоо, судалгаа, өмнөх онд хэрэгжиж байсан болоод зөвлөмж, дүгнэлт өгсөн байгууллагуудын мэдээллүүдийг хүргэсэн. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө тухайн эл үйл ажиллагаандаа зөвлөмж, дүгнэлтийг гаргах байнгын ажиллагаатай ажлын хэсэг байгуулаад 2022 онд 3, 2023 онд 15, 2024 онд 9, мөн 21 аймагт нийт 48 зөвлөмж, дүгнэлтийг гаргаж, мэдээлэл хариуцагч байгууллагуудад хүргүүлсэн.

Байгууллагаар нь дурдах юм бол геологи уул уурхай, мэдээллийн системийн өргөтгөл, сайжруулалт хийх тухай, сонгуулийн мэдээллийн систем, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хэрэглэгдэх систем, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх andmed систем, Дижитал аймаг Архангай, Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн систем, номын сангийн программ, уул уурхайн кадастрын төрөлжсөн систем, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн tzmoh.gov.mn программ, хилийн боомтын мэдээллийн систем төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээллийн мэдэгдэх хүргэх систем, төрийн.../минут дуусав./

Ж.Золжаргал: 6 номерын микрофон нэмээд өгөөрэй.

П.Алтан-Од: Гэх мэт 48 зөвлөмж, дүгнэлтийг манай ажлын хэсэг хүргэсэн байгаа. Практикт тодорхой хүндрэлүүд үүсэж байгаа. Энэ хуулийн хэрэгжилт дээр. Байгууллага цахимд шилжсэнээр цаасан болон цахим хэлбэрийн давхардал үүсгэх, бодитойгоор цаасаар мэдээллээ солилцож байгаа ч гэсэн цаасан архивыг заавал үүсгэх гээд бодит хүндрэлүүд үүсэж байгааг төрийн байгууллага, бусад систем ашиглагч байгууллагуудаас ингэж байгаа. Тэгэхээр энэ давхардал, хийдлийг цаашид бууруулах асуудал тулгарч байна.

Эрүүл мэндийн салбарт өвчний түүхийг цахим системд оруулсан ч эмч нар давхар цахимаар заавал хадгалах ийм бас ачаалал үүсгэдэг. Зөвшөөрөл, тайлан зэргийг цахимаар авч байгаа ч цаасан хувийг нь нөхөж заавал авч бүртгэж байгаа. Хувийн этгээд цахимаар байгуулахад дийлэнх алхам цахимжсан боловчиг цахимаар данс нээх улсын бүртгэгч эх хувиудыг иртэл нь бүртгүүлэх боломжгүй, системд оруулах боломжгүй байдлаар ингээд ийм хүндрэлүүд үүсэж байгаа.

Шийдлийн хувьд shilen.gov.mn хуульд нээлттэй байхаар заасан нээлттэй мэдээлэлд тогтмол оруулах 5000 байгууллага байгаа.gov.mn зөвлөмж, дүгнэлт авах системийг нэвтрүүлсэн байгаа. Бүх төрийн байгууллага нийтийн мэдээллийн систем хөгжүүлэгч байгууллагууд зөвлөмж, дүгнэлтээ энэ сайт руу шууд оруулаад цахимаар бүх мэдээллийг зөвлөмж, дүгнэлт авах ийм боломж байгаа.

Досх-ийг төрийн байгууллагууд дээр холбогдсон боловч албан хэрэг хөтлөлтийн систем дээр нэгдсэн байдлаар бас хангалттай ашиглаж өгөхгүй байна. Цаасан хэлбэрээр мэдээллүүд солилцоод явсаар байгаа. Opendata.gov.mn жагсаалтаар батлагдсан нээлттэй өгөгдлийн хэрэглэгч ашиглахад хялбар байдлаар оруулах агуулгаар нь ингэж бас ашиглаж яваад байна гэж.

Гэрээ, хэлцэл, тоон гэрээ, хэлцэл дээр тоон гарын үсэг ашиглах хэлцэл уламжлал ёсоороо ингээд яваад байгаа. Энийг бол бас тоон гарын үсгээр гэрээ, хэлцлийг хийдэг байх. Бусад хөгжилтэй хөгжингүй орнуудын бас энэ дэвшлийг бид нар бас нутагшуулах чиглэлээр Худалдаа аж үйлдвэрийн танхим, холбогдох байгууллагууд дээр ажиллаж байгаа.

Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын асуудал дээр цахим хэлбэрээр хадгалсан мэдээллийг цаасан хэлбэрээр давхардуулж хадгалахгүй байхаар бид ингээд зохицуулалтыг бас ийм шийдлүүд, бодитойгоор хүлээлт үүссэн байгаа.

Ингээд Байнгын хорооны гишүүддээ мэдээлэл өгч дууслаа. Холбогдох асуултад хариулахад бэлэн байна.

Ж.Золжаргал: Энэ чинь Пунсалмаа хоёулаа л үлдчихлээ. Та асуух асуулт асуух уу? Пунсалмаа гишүүн асуулт байна уу? Пунсалмаа гишүүний микрофоныг нээж өгөөч. Пунсалмаа гишүүний микрофон нээж өгнө үү.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Төрийн байгууллагуудын мэдээллийн хоорондын солилцоо ер нь хэр явагдаж байгаа вэ гэдэг талаар би сая мэдээлэл сонслоо. Ер нь бол бас цаасаар заавал баталгаажуулах шаардлагатай байгаа нь ер нь бол яамдуудын хооронд цаасан мэдээлэл дамжих үндэс, суурь болоод байгаа юм байна. Энийг шийдвэрлэх аргыг энэчээ ер нь шийдэл хайж байна гэж би ойлгож байна.

Тэгэхээр зэрэг ер нь бол энэ цаасан мэдээллийг таг хайгаад хаячихвал бас мэдээллийн аюулгүй байдал, сая кибер бас аюулгүй байдлын асуудал үүссэн гээд энэчээ бас эрсдэл байгаа учраас энэ цаасан мэдээллийг дамжуулж байгаа байх. Тэгэхээр зэрэг энийг бол таг хаах нь бас зөв шийдэл мөн үү, үгүй юү? Энэ дээр өөр бас улс орнууд ямар арга механизм хэрэглэж байна уу нэгдүгээрт?

Хоёрдугаарт, энэ цахим гарын үсэг шилжчихсэн байгаа. Гэхдээ аливаа нэгэн гэрээ баталгаажуулалт хийхэд нотариат дээр заавал цахим гарын үсгийг очиж байж зурж байгаа. Тэгэхлээр энэ цахим гарын үсэг гэххээд өөрөө ингээд ийм

явдал чирэгдлийн асуудал үүсгэх гэж байгаа энэ түгжрэл бөглөрлийн үед ийм цахим гарын үсгийн шийдэл нь цаашид сайжруулах өөр ямар боломж бололцоо байна вэ?

Гуравдугаарт, энэ кибер аюулгүй байдлын түвшиндэнэ big data энэ яамдуудын энэ цаасан мэдээллийг дамжуулахыг хориглоод бүгдийг нь big data болгочихдог энэнийхээ аюулгүй байдлыг нь сайжруулах энэ кибер аюулгүй байдлыг нь нэмэгдүүлэх дээр бид дорвитой арга хэмжээ авах цаг болчихсон. Монгол Улс бол засаг, газар нутгийн хувьд бол бас нэлээн бас далайд гарцгүй ийм орны хувьд ийм кибер аюулгүй байдлаа чангатгаад энэ тал дээрээ илүү давуу байдлыг бас бий болгох боломж байгаа. Тэгээд эдгээр зүйлүүдийг бас хууль дээр суулгахад та нарын зүгээс бидэнд санал болгох шийдлүүд ямар шийдлүүд байгаа вэ?

3 номерын микрофон нээж өгнө үү.

Б.Бат-Өлзий: Сайн байна уу? Тус яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Бат-Өлзий хариулъя.

Пунсалмаа гишүүний эхний асуултад энэ тухайн яг архивын гол асуудал ямар асуудал байгаа юм бэ гэхээр энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 зарчмын яг гол зарчмын нэг нь бол иргэнээс дахиж мэдээллийг нэхэхгүй мөн дахиад юу нь цаасан болон цахим баримт бичгийг эн тэнцүү гэж үзнэ гэсэн энэ зарчим байгаа.

Эн тэнцүү зарчим бол ер нь хуулиараа үүсчихсэн бодитоор болж байгаа. Гол нь зөвхөн архивын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам дээрээ өөрөө журмаа одоо болтол шинэчлээгүйгээсээ болоод заавал журмаараа дахиж тэр бичгийг хадгалсаар л байгаа. Цаасаар хэвлэж гаргаж ирээд тамга дараад буцаагаад хадгалж байгаа. Тэгэхээр одоогийн байдлаар энэ та бүхнээс хүсэх гол яагаад шийдлүүд дунд оруулсан юм бэ гэхээр та бүхнээс бас энэ Архивын еөрөнхий газрыг бас ингээд нийтлэг журмаа шинэчлээч ээ, хуульдаа нийцүүлээч ээ гэдэг ийм бас шаардлага бас үүргийг өгүүлэхийг хүсэж байгаа юм. Тэр талаасаа бас шийдэл гэж ярьсан юм.

Хоёр дахь цахим гарын үсгийн хувьд энэ өөрөө цахим гарын үсгээр гэрээ хийх боломж нь нээгдсэн. Зөвхөн 1 удаа тэр цахим гарын үсгийгээ баталгаажуулаад өөрийн биеэр очсоноос хойш ер нь гэрээ, хэлцлүүд бүгд цахимаар явж болж байгаа. Цахимаар явснаараа энэ мэдээж цаг хэмнэж байгаа. Дээрээс нь бас ер нь цаасаар явахаас илүү цахим гарын үсгийн энэ нууцлал, аюулгүй байдлын хамгаалалт илүү сайн гэж үзэж байгаа юм олон улсын туршлагаар.

Тэгээд бид нар бас энэ тоон гарын үсгийн техник технологийн шинэчлэлийг ирэх жилээс хэрэгжүүлээд олон улсын аудитыг хийлгэхээр ажиллаж байгаа. Олон улсын аудит хийлгэснээрээ Монгол Улсын бас энэ цахим гарын үсгээр баталгаажсан гэрээ контрактууд олон улсад хүлээн зөвшөөрөгдөх юм. Тэгэхээр ингэж хүлээн зөвшөөрөгдсөнөөрөө илүү тоон гарын үсэг, цахим гарын үсгийн маань хэрэглээ ер нь өндөр болох юм аа гэж үзэж байгаа юм. Кибер аюулгүй байдлын талаар манай кибер хэсэг болгон хариулах уу?

Ж.Золжаргал: Золбаяр даргын, хэд дээр 4? 4 номерын микрофон нээж өгнө үү.

Ч.Золбаяр: Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Золбаяр байна. Пунсалмаа гишүүний асуултад хариулъя.

Нийтийн мэдээллийн тухай хуулиар мэдээлэл хариуцагч гэдэг ойлголт байгаа. Ер нь бүх мэдээллийг хариуцаж боловсруулж байгаа байгууллага бол мэдээлэл хариуцагч гэсэн ийм ангилалдаа ороод явна. Тэгэхээр энэ Нийтийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т зааснаар мэдээлэл хариуцагч нь хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд нийтийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, удирдлага зохион байгуулалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, шаардлагатай бусад арга хэмжээ авах үүрэгтэй гэж байгаа юм.

Тэгэхээр мэдээлэл хариуцагч яамдууд болон бусад төрийн байгууллагууд бол өөрийн цуглуулж байгаа, боловсруулж байгаа системийнхээ мэдээллийн аюулгүй байдлыг бол өөрсдөө хангах ёстой байгаа. Кибер аюулгүй байдлын тухай хуулиар бол хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг нь Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд бодлогын чиглэлээр байгаа. Хэрэгжилтийг уялдан зохион байгуулах тухайн кибер гэмт хэрэг, кибер эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд уялдуулан зохицуулах болон.../минут дуусав./

Ж.Золжаргал: 4 номерын цаг нэмж өгнө үү.

Ч.Золбаяр: Мэдээллээр ханган зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг нь бол ажлын албан дээр оногдож явж байгаа. Яг та бүхний мэдэж байгаагаар бол саяхан Инновац цахим бодлогын байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу бас манай Кибер аюулгүй байдлын зөвлөл хуралдаад яг энэ асуудал дээр ер нь кибер аюулгүй байдлаа хамгаалах тал дээр, ялангуяа төр захиргааны байгууллагууд, төрийн байгууллагууд үүн дээр төсвийн болон бүтцийн зохион байгуулалт дээр онцгой анхаарах шаардлагатай байна гэдэг тогтоолыг гаргасан. Энэ тогтоолын дагуу бас Байнгын хороо болон бусад байгууллагууддаа бид тогтоолоо хүргүүлсэн байж байгаа. Энэ дагуу бол Сангийн яаманд мөн энэ кибер аюулгүй байдлыг хангах тал дээр төсвийн шинэ ангиллын үүсгэж энэ дээр тодорхой зардлаа тусгуулах, мөн цаашлаад кибер аюулгүй байдлыг хангах тодорхой албан тушаалтан буюу үүнийг зөвхөн мэргэжлийн гэхээсээ илүү кибер аюулгүй байдлыг хангах албан тушаалтныг томилж байлгах нь өөрөө маш үр дүнтэй гэж үзэж байгаа болохоор энэ асуудлыг бол бид холбогдох төрийн захиргааны байгууллагуудад нь бол сайдын шугамаар дамжуулагдаад хүргүүлсэн байгаа.

Ж.Золжаргал: Пунсалмаа гишүүн хариултаа авч болсон уу тээ? Баярлалаа.

Би та бүхэндээ түрүүн тэгвэл дурдаж байсан асуултуудаасаа бас тодруулж асууя. Энэ нээлттэй мэдээлэл гээд байгаа шүү дээ? Хуулийн 8 дугаар зүйл заалт, энэ нээлттэй нийтдээ 68 байна лээ бид тоолж гаргасан юм. Тэгээд их сонирхолтой мэдээлэл, төсвийн гүйцэтгэлийн биелэлт, хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан энэ тэр гээд их өргөн хүрээтэй. Тэгэхээр энэ мэдээллүүд нээлттэй байх ёстой Монгол Улсад. Тэгээд үүний чиглэлээр энэ заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр та бүхэн ямар бодолтой, байр суурьтай байгаа вэ гэж?

Хоёрдугаарт нь тэр 2022 оны 9 сард хийсэн энэ цахим системүүд дээр хийсэн анализ, 24 оныг дуустал хийсэн юм байна лээ. Тэгээд энийг та бүхэн би дахиад хийж байгаа гэж ойлгосон. Мэдээлэл хүссэн бичиг явуулсан байгаа. Би Алтан-Од даргатай бас утсаар ярьсан. Энэ нь ямархуу байдалтай байгаа вэ? Энэ мэдээллийг ер нь шинэчлэх үү?

7 номерын микрофон нээж өгнө үү.

Байнгын хорооны дарга дарга асуусан асуултад хариулъя.

П.Батбаатар: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль бол үндсэндээ яг таны хэлснээр 5 чиглэлийн 68 мэдээллийг ил тод болгох ёстой байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт, shilen.gov.mn гэсэн цахим системээр бол энэ 68 мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр нээлттэй ил тод болгож, иргэдийн мэдэх эрхийг нээж өгсөн ийм асуудал байгаа.

Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бол үндсэндээ Шилэн дансны хуулийн дагуу шилэн дансны мэдээлэл шилэн данс систем дээр мэдээлэл бас байршуулж байгаа. Энийг бол цаашдаа Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас бол нэгтгээд shilen.gov.mn дээр бүх мэдээллийг нэг байдлаар оруулахгүй бол үндсэндээ Сангийн яаман дээр нэг систем дээр мэдээлэл орж байдаг, бусад байдлаар энэ бол Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл дээр заасан мэдээлэл хариуцагч нийт 5527 орчим байгууллагууд бүгд мэдээллээ оруулахаар заасан хуулийн зохицуулалттай байгаа. Тэгэхээр энэ 2 системийг хооронд нь нийлүүлж, иргэдийг нэг үндсэн системээс бүх төрлийн мэдээллийг нээлттэй ил тод байхаар зохицуулахаар ажлын хэсэг ажиллаад явж байгаа.

Ж.Золжаргал: Ажлын хэсгээ та жоохон тодруулаад хэлээч. Ямар бүрэлдэхүүнтэй, ямархуу шатад явж байгаа юм бол? Ажлын цар хүрээ нь?

П.Батбаатар: Ажлын хэсэг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаман дээр байгуулагдсан сайдын зөвлөх Тулгатаар ахлуулаад Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Үндэсний дата төвийн бүрэлдэхүүн ороод одоо shilen.gov.mn цахим системийг эрчимжүүлэх, байгууллагуудыг мэдээллээ ил тод нээлттэй болгоход нь бол заавар, зөвлөгөө өгөх системийг дараагийн түвшинд сайжруулах ийм ажлын хэсэг гарсан. Ажилдаа ороод ингээд явж байгаа.

Ж.Золжаргал: Хоёрдугаар асуулт 6 номерын микрофон.

П.Алтан-Од: Төрийн хяналт үнэлгээний Үндэсний хороо яам болоод бусад байгууллагуудаар өргөтгөсөн ажлын хэсэг 2023 онд гаргаад 24 оны 2 сар хүртэлх ажлын хэсгийн дүгнэлтээр ерөнхийдөө 455 орчим төрийн систем, программ хангамж бүхий систем байна гэж тоолсон. Албан ёсоор Байнгын хорооны даргын илтгэлд дурдсан шиг 2 их наяд төгрөгийн санхүүжилт гэдэг мэдээллүүдийг ер нь бол тоон мэдээллээ шинэчлэх тал дээр яам ажиллаж байгаа. Төрийн мэдээлэл эзэмшиж байгаа энэ төрийн байгууллагын 5000 орчим төрийн байгууллага руу холбогдох систем бий болгож хөгжүүлж байгаа байгууллагууд руу бүгд рүү нь хүсэлт хүргүүлж, одоо ингээд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу та бүхэн маань бүртгүүлэх, цаашид бас ингээд мэдээлэл дээрээ санал,

дүгнэлтээ авдаг байхад ингээд зөвлөмж хүргүүлсэн байж байгаа. Энэ ондоо ер нь эхний улирлын байдлаар.../минут дуусав./

Ж.Золжаргал: Нэмэлт цаг өгье. 6 номер.

П.Алтан-Од: Монгол Улс хэдэн яг энэ программ хангамж систем хөгжүүлэлт хийсэн юм, ингээд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд бас заасанчлан санал, дүгнэлтүүдээ авдаг Төсвийн тухай хуульдаа уялдуулж бас энэ ажлын хэсгээрээ дүгнэлтүүдээ гаргуулдаг эд нар гээд. Сангийн яаман дээр яг энэ мэдээллийн системтэй холбоотой төсөв дээр яг тоо нэгдсэн тоон мэдээлэл байхгүй талаар бас юу хэлсэн. Тэгэхээр анхан болоод олон улсын байгууллага төр, хувийн хэвшлийн хүрээнд хийгдсэн бүх нөгөө суурь үүнтэй нь хамт судалгаа авахаар бас яамнаас төрийн байгууллагууд руу хандчихсан байж байгаа. Тэгээд судалгааны дүнг 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэж гаргахаар ажиллаж байна.

Ж.Золжаргал: 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэж гаргах юм байна гэж ойлголоо. Тэгээд энэ жилийн төсөв дээр бас гараад байсан шүү дээ бид ярьж байсан тоног төхөөрөмж гээд ангилал дотор, энэ зүгээр та бүхэнд мэдээлэл хуваалцаж байгаа юм. Тоног төхөөрөмж гэдэг ангилал дотор жишээ нь компьютер байж байгаа, эмнэлгийн фургон байж байгаа, өөр нисдэг тэрэг юу байдаг юм бүгд ингээд холилчихсон байдаг тээ. Мэдээллийн технологийн үйлчилгээ гээд нэг ангилал байдаг. 4 түвшинтэй ийм ангилал байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар яг мэдээллийн технологийн чиглэлээр, энэ цахимжилтын чиглэлээр зарцуулж байгаа төсвөө ангилалыг нь тусад нь ялгаж аваад тэгээд зориулалтаар нь задлахгүй бол тоног төхөөрөмжүүдтэйгээ хамт программ яваад байдаг. Эс үгүй бол тэр заримыг нь нуудаг, эсвэл зарим дээр нь илүү төсөв, дутуу төсөв байдаг тиймэрхүү зүйл ажиглагдсан. Бид нар бас нэлээн олон байгууллагуудаас мэдээлэл авсан байгаа.

Тэгэхээр энэ ангилал дээр байгууллагууддаа, энэ Байнгын хорооны ажлын албаны зүгээс санал гаргаад хүмүүстэй уулзаад ангилал хийгээд явж байгаа. Сангийн яамныхантай бас уулзсан. Тэгэхээр удахгүй бүгдээрээ яг тийм тодорхой асуудал дээр эхлээд ангиллаа бэлдчихээд тэгээд дараа нь ингээд албан ёсны хуралдаанаа хийгээд тогтоол гаргах байдлаар явъя гэсэн бодолтой байгаа.

Нээлттэй мэдээллийн талаар ажлын хэсэг Тулгат зөвлөх ахалж яваа юм байна. Тэгээд бид сая энэ төсөв дээр жишээлбэл маш их яриа болж байгаа шүү дээ Улсын Их Хурал дээр. Ер нь цаашдаа улсын төсөв угаасаа нийтэд ил байх ёстой, мэргэжлийн хүмүүс нь ороод харж болдог байх ёстой, гүйцэтгэлийг нь, хяналтыг нь хийдэг. Тэгэхээр тэрийг ийм төвөгтэй, хэцүү биш, хүнд ойлгомжтой тиймэрхүү ил тод байх хуулиараа тавьчихсан шаардлагынх нь хүрээнд зохицуулах дээр бас та бүхэн онцгой анхаарал хандуулаарай гэж хүсье.

Ингээд асуулт үг хэлж дууслаа.

4 номерын микрофон нээж өгнө үү.

М.Тулгат: Эрхэм байнгын хорооны дарга гишүүдийн амрыг айлтгая. Өнгөрсөн 7 хоногт.

Ж.Золжаргал: 4 нээчихсэн үү?

М.Тулгат: Өнгөрсөн 7 хоногт Нээлттэй мэдээллийн тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх штаб гэж нэрлэж байгаа. Энэ бол шилэн ажиллагааны штабын бүрэлдэхүүнийг өөрчилсөн ийм тушаал гараад ингээд ажилд ороод явж байна. Тэгээд түрүүн Байнгын хорооны дарга болон Пунсалмаа гишүүн Байнгын хорооны гишүүний тавьсан асуулт дотор гарч ирсэн зүйл дээр бас нэмэлтээр мэдээлэл өгөхөдтэр 5576 байгууллагаас одоогийн байдлаар 170 гаруй байгууллага мэдээллээ оруулаад явж байгаа. Тоогоороо харахад бас хангалтгүй харагдаж байгаа. Гэхдээ энэ 5000 гаруй байгууллага дотор жишээлбэл орон нутгийн, сумын сургууль, цэцэрлэг гэдэг ч юм уу ингээд төрийн захиргааны, төрийн үйлчилгээний маш олон салбар байгууллагуудын асуудал бүгд ороод ингээд яригдах ийм зүйл болж байгаа. Тэгэнгүүт бодит амьдрал дээр хүн хүчний, хүний нөөцийн асуудал гэдэг ч юм уу, чадамжийн асууда тухайн сумын сургууль, сумын цэцэрлэгийн тэр пэйж хуудсан дээрээ тавих ёстой мэдээлэл ёстой мэдээлэл гэдэг ч юм уу иймэрхүү асуудлууд бас гарч ирдэг.

Үүнийг бол яамны зүгээс болоод, манай дэргэдэх агентлагийн зүгээс бол энэ дээрээ хуваарилалт хийгээд ингээд ажиллаад явна. Тэгээд та бүхэнд өгөх гэж байгаа мэдээлэл маань юу вэ гэхээр ер нь энэ олон төрийн сайтууд, системүүдийг нэгтгэх интеграцлах чиглэл рүү явж байгаа. Энэ хүрээнд цаашдаа gov.mn гэдэг нэгдсэн сайт бий болгож байгаа. Та бүхэн бас энэ талаар мэдээлэл авч байсан байх.

Тэгэхээр өмнө нь бол яам, агентлаг, төрийн байгууллагууд өөр өөрийн дизайнтай, өөр өөрийн формат хэлбэртэй ийм олон сайтуудтай байдаг байсан бол үүнийг нэгтгээд Монгол төр нэг энэ gov.mn гэдэг ийм нэгдсэн форматтай ийм мэдээллийн сайтыг бий болгоё гээд. Тэгэнгүүт энэ олон төрийн, ялангуяа энэ орон нутгийн засаг захиргааны байгууллага гэдэг юм уу, салбар энэ байгууллагуудын мэдээллүүд ороод явахад илүү дөхөмтэй болно. Түүнийг бас энэ штабын зүгээс энэ шилэн үнэлгээг гаргаж байгаа энэ хариуцсан улсуудын зүгээс үнэлгээ хийхэд өнөөдөр тулгамдаж байгаа нэг асуудал бол механик ажиллагаа ихтэй байгаад байгаа юм. Эд нарыг болтэр gov.mn-ээр хийснээр хөнгөвчлөх, илүү автоматжуулах гэсэн ийм зүйлүүдийг зорилго болгоод явж байгаа гэдэг мэдээллийг бас хүргэх нь зүйтэй байх гэж бодлоо.

Ж.Золжаргал: Баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Баярлалаа.

Энэ авлигыг бууруулах, төсвийн үргүй зарцуулалтыг багасгах гээд ер нь бол манай цахимынхны оролцоо маш чухал. Ер нь шийдэл нь бараг цахим талаасаа л гарах болов уу. Тэгэхээр энэ дээр та бүхэн бас сонирхолтой шинэ санаачилга гаргаад ажиллаж байгаа юм байна. Амжилт хүсье.

Байнгын хорооны зүгээс аль болохоор ойрхон ажиллаж байгаа. Ер нь салбарын хүмүүстэй бас уулзаад байгаа. Тэгэхээр бид нар энэ уулзалт хурлынхаа арга барилыг бас жоохон өөрчлөхгүй бол энэ төрийн том байгууллагын дарга, захиралыг бүгдийг нь цуглуулчихаад гишүүд нь бас тогтмол оролцож чадахгүй. Ингэж байхаар ажлын хэсгүүд хэд хэдэн чиглэлээр гарчихсан явж байгаа. Цахим чиглэлээрээ, саинбох-ын чиглэлээр байна, виртуал хөрөнгийн чиглэлээр байна, хиймэл оюуны чиглэлээр гэх мэтчилэн яг тэр ажлын хэсгүүд дээрээ бас шуурхай уулзалтуудаа хийгээд, гарсан дүгнэлтээ тогтоол гаргах тохиолдолд Байнгын хороогоо илүү хуралдуулаад явах нь зөв юм байна.

Та бүхэндээ ирсэнд баярлалаа. Амжилт хүсье.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд хэлэлцэх асуудал дууссан тул хурал өндөрлөлөө. Баярлалаа.

16.16 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР